



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1/204

Чингис хот

Мал сүрэгт үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.16, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бог малын хээлтүүлэгч, цөм сүргээр бүртгэгдсэн мал болон ноолуурын чиглэлийн Галшарын улаан омгийн ямаа, хурдны чиглэлийн Галшар үүлдрийн адуу, Дадал суманд үржүүлэгдэж буй сүү-махны хосолмол ашиг шимтэй үхэр, Дархан суманд үржүүлж буй нутгийн тэмээ, Хэрлэн сумын Төрийн өмчит цөм сүрэг болох мах-ноосны чиглэлийн нарийвтар ноост "Тал Нутгийн Цагаан" үүлдрийн хонинд үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэн, ээмэгжүүлж баталгаажуулах ажлыг төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Гантөмөр	Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга
Гишүүд:	Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга
	Б.Сүнгээ	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Э.Саранжил	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

3. Сумын дэд ажлын хэсгийг сумдын Засаг даргын захирамжаар томилон, хэрэгжилтийг хангуулан ажиллах, тайлан мэдээг удирдамжид заасан хугацаанд ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

231010543

2.

4. Сумдын Хөдөө аж ахуйн тасаг, малын үржүүлэг технологийн нэгжүүдийн мал сүрэгт үзлэг ангилалт, ээмэгжүүлэлт хийсэн ажилд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т, үр дүнг мэдээлж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т тус тус үүрэг болгосугай.

5. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж, ээмэгжүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлын нэгдсэн дүнг удирдамжид заасан хугацаанд Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар, Малын генетик нөөцийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч бөгөөд аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА